

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН



АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ _____	3
Товч танилцуулга 2015 оны онцлох үйл явдал	
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА _____	4
Компанийн засаглал Компанийн нийгмийн хариуцлагын бодлого Оролцогч сонирхогч талуудын хамтын ажиллагаа Өргөдөл, гомдол барагдуулах механизм	
АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА _____	6
Хүний нөөцийн удирдлага Ажлын байр, тэгш боломж Ажиллагсдын нийгмийн халамж Ажиллагсдын шилжилт хөдөлгөөн Сургалт, хөгжил	
ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР _____	9
Татвар төлөлт Орон нутгийн хөрөнгө оруулалт Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	
БАЙГАЛЬ ОРЧИН _____	13
Байгаль орчны бодлого, үйл ажиллагаа	
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ _____	16
Хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлага, чиг баримжаа Сургалт, зааварчилгаа	

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд анхаарна
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг. Иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

КОМПАНИЙН ТУХАЙ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг. Монголын үндэсний компаниудаас анх удаа 2010 оны 10-р сард Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд гарсан.

Тус компани нь 2009 оноос Ухаа Худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, орон сууцны хороолол, 700 хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэг зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолборыг бий болгосон.

Ингэснээр нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн Монгол Улсын хөгжил дэвшил, үйлдвэржилтэд бодитой хувь нэмрээ оруулах зорилгоо биелүүлэн ажиллаж байна.

2015 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Тайлант онд компани үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиосон. Анх 2005 онд Монголын үндэсний компаниуд нэгдэж, Энержи Ресурс компанийг үүсгэн байгуулсан бөгөөд хийж бүтээсэн бодит ажил үйлс, бүтээн байгуулалтаараа үндэсний хэмжээний томоохон уул уурхайн компани болж хөгжсөн. Өнгөрсөн хугацаанд тус компаниас Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан бодит хувь нэмрээс тоймловол:

- Татвар төлөлтөөр улсын хэмжээнд тогтмол “айрагдаж” ирсэн бөгөөд үйл ажиллагаа эхэлсэн 2009 оноос өнөөг хүртэлх хугацаанд улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 760 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлсэн;
- Уул уурхай, үйлдвэрлэл, усан болон цахилгаан эрчим хүчний хангамж, нийгмийн дэд бүтцийн цогц бүтээн байгуулалтын ажилд 1.2 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;
- Дотоодын 2,700 гаруй аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч хэлбэрээр хамтран ажилласан бөгөөд тэднээс 2.6 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч, дотоодын эдийн засгийн эргэлтийг дэмжсэн;
- Үндэсний боловсон хүчний нөөц боломжид тулгуурласан бүтээн байгуулалт хийж, үйл ажиллагаа явуулснаар 3,000 гаруй иргэн шууд ажлын байраар хангагдан ажилтай, орлоготой байгаагийн 40 гаруй хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж ирсэн.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн зах зээлд хөл тавьсан хувьцаат компани гэдэг утгаараа компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчдийн эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд онцгой анхаарч ирсэн.

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх бодлогын хүрээнд дотоодын болон олон улсын сайн засаглалын шаардлага, стандартуудыг мөрдөхийн зэрэгцээ шийдвэр гаргалтын оновчтой, энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэх байдлаар дотоод дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Мөн 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Энержи Ресурс компани нь олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохыг зорин ажилладаг.

Компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг хэрэгжүүлэх үүднээс "ISO26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж" болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжинд үндэслэн КНХ-ын бодлогоо 2011 онд боловсруулан батлуулж, компанийн бүх салбар болон охин компаниудад танилцуулан, мөрдөж ирсэн.

Компанийн зүгээс оролцогч сонирхогч талуудтай нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэн ажиллаж, уг зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа орон нутгийн иргэд, олон нийт, хөрөнгө оруулагчид болон төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй, тогтмол тайлагнаж ирсэн.

Өдгөө тус компани нь уул уурхайн салбарын хэмжээнд нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч шилдэг компанийн нэгээр нэрлэгдэж, оролцогч талуудынхаа итгэлийг хүлээн, нийгмийн зөвшөөрлөө зүй ёсоор ханган ажиллаж байна.

ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энержи Ресурс компани нь оролцогч болон сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, мэдээлэл, туршлага солилцох, үйл ажиллагаандаа хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх, тайлагнах зэргээр хамтран ажилладаг.

Энэ дагуу компанийн үйл ажиллагааны талаар үнэн, зөв мэдээлэл түгээж, иргэдтэй нүүр тулж уулзан, тэдний санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэлэлцүүлгийг 2009 оноос эхлэн жил тутам зохион байгуулж ирсэн.



Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцаа хөгжүүлж, шийдвэр гаргалтанд тэдний дуу хоолойг тусгах, оролцоог хангах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд зэрэг нөлөөллийн сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулж, хамтран ажилладаг.

Малчид, иргэдийн зүгээс компанийн бүтээн байгуулалтын ажлууд, байгаль орчны мониторинг, нөхөн сэргээлтийн ажилд сайн дурын хяналт тавих байдлаар оролцдог нь компани болон иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлж байна.

Оролцогч, сонирхогч талуудыг мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа ил тод байлгах үүднээс орон нутагт мэдээллийн төв ажиллуулж, сар тутмын “Ухаа Худаг” мэдээллийн хуудсаар дамжуулан сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл хүргэж, үйл ажиллагааны болон нийгмийн хариуцлагын тайланг тогтмол хугацаанд олон нийтэд нээлттэй тайлагнаж байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Компанийн үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд үүсч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлж, цаг тухайд нь арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч, 30 хоногийн дотор хариу мэдээлэх журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг утсаар, цахим шуудангаар, бичгээр болон иргэдтэй биечлэн уулзах байдлаар хүлээн авдаг.

2015 онд компанийн хэмжээнд нийт 3 гомдол, 30 хүсэлт хүлээн авсан. Эхний гомдол нь шатахуун тээвэрлэгч машинууд маршрутын дагуу явахгүй, салаа зам гаргаж байгаа тухай байсан бол хоёр дахь нь айлын байшин шатахад компанийн аврах албыг дуудсан боловч хугацаа алдаж ирсэн тухайд нутгийн малчнаас ирүүлсэн гомдол байв.



Эхний гомдол нь компанийн үйл ажиллагаатай шууд холбогдолгүй байсан хэдий ч гомдлын мөрөөр шатахуун нийлүүлэгч гэрээт компаниудтай холбогдож, хатуу хүчилттай замгүй чиглэлүүдэд тээвэр хийхдээ салаа зам гаргахгүй байх, зохих маршрутын дагуу явах, маршрут батлахдаа орон нутгийн захиргаатай зөвшилцөж байх тухай мэдэгдэл хүргүүлсэн. Хоёр дахь гомдлын тухайд компанийн аврах алба нь орон нутгаас ирсэн дуудлагуудыг аль болох хүлээн авч, тусламж үзүүлэхийг зорьдог хэдий ч аврах тусламж зайлшгүй үзүүлэх албан үүргийг төр захиргааны өмнө хүлээгээгүй болно. Иймд уг байдлыг гомдол гаргагчид мэдэгдэж, тухайн үед аврах алба ачаалал ихтэй байсныг тайлбарласан.

Гуравдахь гомдол нь компанийн нохой нутгийн малчны мал руу дайрсан гэх утгатай байсан. Гомдлын дагуу компанийн орон нутгийн ажилтнууд гомдол гаргагчтай биечлэн уулзаж, компанийн зүгээс ямар нэгэн мал амьтан тэжээдэггүй болохыг албан ёсоор мэдэгдсэн.

Тайлант хугацаанд хүлээн авсан нийт 30 хүсэлтийн 40% нь компаниас хандив, тусламж хүсэх тухай, 10% нь бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх, гэрээ байгуулах, хамтран ажиллах тухай, 9% нь Ухаа Худаг уурхайтай танилцах тухай, бусад нь худаг ус гаргуулах, уурхайд дадлага хийх, хаягдал түүхий эд болон тоног төхөөрөмжийн туслалцаа авах зэрэг хүсэлтүүд байлаа. Нийт өргөдөл гомдлын 93.4%-ийг 30 хоногийн дотор шийдвэрлэж, тухай бүр хариу өгсөн байна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Ажиллагсад нь компанийн амжилтын гол хүчин зүйл учраас чадварлаг боловсон хүчин бий болгох, тогтоон барих, сурган хөгжүүлэх нь Энержи Ресурс компанийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Иймээс Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн хүний нөөцийн бодлогын хүрээнд ажлын байрны эрүүл, аюулгүй нөхцлийг бүрдүүлж, ажиллагсдынхаа нийгмийн асуудал, шилжин суурьших нөхцлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг хангахад онцгой анхааран ажиллаж байна.

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдын эрхийг дээдэлж, тэднийг ижил тэгш боломжоор хангадаг. Ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн.

АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ

Тайлант онд зах зээлийн хүндрэл үргэлжилсэн хэдий ч компанийн зүгээс ажиллагсдынхаа ажлын байрыг хадгалах, тэр дундаа орон нутгийн иргэдийг ажил, орлоготой нь хэвээр байлгах чиглэлд түлхүү анхаарч, компанийн бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтой болгон шинэчилсэн.

Ийнхүү боломжит дотоод нөөц, бололцоогоо дайчлан ажилласны хүчинд Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй бусад уул уурхайн компаниудтай харьцуулахад ажиллагсдынхаа ажлын байрыг тогтвортой хадгалж үлдсэн. 2015 оны 12-р сарын байдлаар тус компани нийт 1,797 үндсэн ажиллагсадтай байсны 45 хувийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян Овоо, Цогт Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.


Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харьяаллаас үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.

Тайлант онд нийт ажиллагсдын 15%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд нийт эмэгтэй ажиллагсдын 15% нь менежер болон удирдах түвшинд, 15% нь мэргэжлийн буюу техникийн түвшинд, 75% нь судлаач, инженер, геологич зэрэг мэргэжилтний түвшинд тус тус ажиллаж байна.


КОМПАНИЙН АЖИЛЛАГСДЫН МЭДЭЭЛЭЛ (2015)

	2013/12/31	2014/12/31	2015/12/31
1. Нийт ажиллагсдын тоо	2,272	1,950	1,797
2. Нийт эмэгтэй ажиллагсдын тоо	324	296	259
3. Удирдах түвшний эмэгтэй ажиллагсдын тоо	9	15	40
4. Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь	43,3%	40,6%	45%


Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь (2015)




Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь (2015)



Ажиллагсдын насны ангилал (2015)



Эмэгтэй ажиллагсдын албан тушаалын байдал (2015)



АЖИЛЛАГСДЫН НИЙГМИЙН ХАЛАМЖ

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмуудыг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн говь нутагт үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг уул уурхайн компани гэдэг утгаараа ажиллагсдыг орон нутагт тогтвортой ажиллуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор шилжин суурьшилтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг.

Нийт ажилтнуудыг даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, шилжин суурьшсан ажилтнуудад орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, тэдний гэр бүлийн гишүүдийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгийн асуудлыг шийдэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулж ирсэн.



Уурхайн ажилтнуудыг тохь тухтай амьдруулах, суурьшуулах бодлогын хүрээнд Цогтцэций суманд барьж байгуулсан орон сууцны “Цэций” хороололд одоогийн байдлаар 600 гаруй ажиллагсад гэр бүлийн хамтаар амьдарч байна. Мөн “Уурхайчин” жишиг гэр хороолол, “Зузаахай” цэцэрлэг болон 700 хүүхдийн багтаамжтай “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолборыг барьж байгуулан ашиглалтанд оруулснаар ажилтнууд ар гэрийн нөхцөл, үр хүүхдийнхээ боловсролд санаа зовох зүйлгүйгээр ажлын бүтээмжээ нэмэгдүүлэн ажиллах боломж бүрдсэн юм.

АЖИЛЛАГСДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2015 онд ажиллагсдын шилжилт хөдөлгөөн 10%-тай байсан нь өнгөрсөн оныхоос 8%-иар буурсан үзүүлэлт юм. Тайлант онд зах зээлийн хямрал үргэлжилсэн хэдий ч компанийн зүгээс ажиллагсдынхаа ажлын байрыг хадгалж үлдсэн төдийгүй тэдний нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр үргэлжлүүлэн, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн зэрэг шалтгаанууд шилжилт хөдөлгөөн багасахад нөлөөлжээ. 2013 оноос хойш нийт 650 ажилтан гэр бүлийн хамтаар орон нутагт шилжин суурьшсан байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж ирсэн. Тайлант онд ерөнхий ур чадварын 15, нарийн мэргэжлийн 3, нийт 18 төрлийн сургалтанд давхардсан тоогоор нийт 145 ажиллагсдыг хамруулжээ.



ТАТВАР ТӨЛӨЛТ

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлсэн цагаас татвар төлөлтөөр улсдаа тэргүүлж, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Тодруулбал, 2009 онд 22 тэрбум, 2010 онд 84 тэрбум, 2011 онд 170 тэрбум, 2012 онд 209 тэрбум, 2013 онд 123 тэрбум, 2014 онд 74 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2015 онд дан ганц нүүрсний салбар гэлтгүй уул уурхайн салбарын хувьд амаргүй, хүндхэн жил байсан боловч компанийн зүгээс дотоод нөөц бололцоогоо дайчлан ажилласны үр дүнд нийт 83 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Орон нутаг төдийгүй улс орны хэмжээнд хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Ухаа Худагт өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн. Тайлант онд нийт 2.4 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц болон орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд, холбогдох бусад ажлуудад зарцуулсан байна.

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал юм. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтрахыг нэн тэргүүнд зорьдог. Өнгөрсөн онд 320 аж ахуйн нэгжээс нийт 450 орчим тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээ худалдан авснаас Өмнөговь аймгийн хэмжээнд хагас тэрбум төгрөгийн бараа материал, тээврийн үйлчилгээ, барилгын материал, ажил үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн худалдан авалт хийсэн байна.

Нийгэм, орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын дүн (2015)

Хөрөнгө оруулалтын чиглэл	/төгрөг/
1. Орон нутгийн дэд бүтцийн хөгжил	1,372,742,750
2. Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	403,455,576
3. Хандив, тусламж	166,000,000
4. Орон нутгийн худалдан авалт	449,194,800
Нийт	2,391,393,126

Орон нутгийн дэд бүтэц, боловсролын хүртээмж, иргэдийн эрүүл мэнд, мэдлэг чадварыг сайжруулахад анхаарал тавихаас гадна малчдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг дэмжих, чадавхижуулах чиглэлээр бие даасан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь нийгмийн олон чиглэлийн суурь судалгааны үр дүн болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагад үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт, засаг захиргааны байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж ирсэн.

Компанийн зүгээс иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг эрхэмлэж, малчин өрхүүдэд өвөл, хаврыг өнтэй давахад нь дэмжлэг болгон өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг жил бүр уламжлал болгон хэрэгжүүлж ирсэн.

Тайлант онд салбарын зах зээлийн нөхцөл байдлаас хамааран компани бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй хэдий ч нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

Говийн сургууль – Мөрөөдлийн сургууль

Одоогоос гурван жилийн өмнө Өмнөговь аймаг болон Энержи Ресурс компанийн хамтын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан, 700 хүүхдийн багтаамжтай “Мөрөөдөл” боловсролын цогцолбор нь богино хугацаанд сургалтын чанараараа аймаг, орон нутагтаа төдийгүй улсад дээгүүр түвшинд үнэлэгдэж эхэлсэн.

Үүний тод жишээ нь тус сургууль элсэлтийн ерөнхий шалгалтын үзүүлэлтээр аймагтаа тэргүүлж, улсад өндөр амжилт үзүүлсэн явдал юм.

2012 онд байгуулагдсан шинэ сургууль анхны төгсөгчдийнхөө улсын шалгалтын дундаж оноогоор ийнхүү өндөр үнэлэгдсэн нь хөдөө, алслагдсан сумын сургалт чанаржиж, сайн боловсрол эзэмших нөхцөл бүрдсэнийг батлан харууллаа.



Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр

Энержи Ресурс компаниас малчин өрхийн амьжиргааг сайжруулах, тэдний бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор “Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг.

Уг хөтөлбөрийн хүрээнд “Говийн хөгжил” орон нутгийн ТББ-тай хамтран нөлөөллийн бүсийн малчдын дунд бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтыг зохион байгуулсны дүнд эхний ээлжинд 14 малчны бизнес төлөвлөгөөг хүлээн авч, орон нутгийн Хас банкттай хамтран бичил зээл олгосон.

Уг зээлийн хүүг компани бүрэн хариуцсанаар малчид зөвхөн үндсэн зээлээ төлж, бизнесээ өргөжүүлэхэд анхаарах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан юм. Хөтөлбөрийн хүрээнд малчдад зөвхөн зээл олгож санхүүгийн дэмжлэг үзүүлээд зогсохгүй тэднийг өрхийн бизнесээ өдөр тутам хөтлөн явуулах, бизнесийн мэдлэгээ сайжруулахад нь орон нутгийн “Амжилтын томъёо”, “Говийн хөгжлийн зуун” ТББ-ууд мэргэжлийн тусалцаа үзүүлж, бизнесийн зөвлөх үйлчилгээ, сургалт, семинаруудыг зохион байгуулсан.



Мөн орон нутагт амжилттай бизнес эрхэлж буй жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулж, малчдыг орон нутагт зохиогдсон үндэсний үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанд оролцуулж туршлага солилцууллаа.

Одоогийн байдлаар зээл авсан малчдын эргэн төлөлт хэвийн үзүүлэлттэй байна. 2015 оны дөрөвдүгээр сард уг хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлуудыг дүгнэх, үр дүнгээ нэгтгэх, хөтөлбөрт хамрагдаж буй малчдын санал сэтгэгдлийг сонсох зорилгоор оролцогч талуудын хамтарсан тайлан уулзалтыг Цогтцэций суманд амжилттай зохион байгуулсан.

Ойн зурвас төсөл

Энержи Ресурс компанийн зүгээс Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран орон нутгийн иргэдийн газар тариалан эрхлэлтийг дэмжих зорилготой “Ойн зурвас” төслийг дөрөвдэх жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг төслийн үр дүнд нийт 180 орчим өрх ногооны талбай эзэмшиж, 18 төрлийн жимс, хүнсний ногоо тариалж, хувийн хэрэгцээндээ ашиглаж байна. 2015 онд төслийн цар хүрээг өргөтгөх зорилгоор усалгааны системийн шинэчлэл хийж, тариалангийн талбайг 4 га-гаар нэмэгдүүлснээр дахин 160 өрх талбай эзэмшиж, жимс, хүнсний ногоо тариалах боломж бүрдсэн. Мөн иргэдэд жимс, хүнсний ногоо тариалах, даршлах сургалтуудыг аймгийн хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан.



Өндөр настнуудад хүндэтгэл үзүүлээ

Энержи Ресурс компаниас орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагууд болон ахмадын хороодтой хамтран Сар шинийн баярыг угтсан хүндэтгэлийн арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг.

Тайлант онд уг арга хэмжээний хүрээнд Ханхонгор сумын 106, Цогтцэций сумын 88, Ханбогд сумын 105, Баян-Овоо сумын 91 буюу нийт 390 ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, сар шинийн баярын гарын бэлэг гардуулсан. Энэ үеэр компанийн удирдлагуудын зүгээс ахмадуудад компанийн ажлыг товч танилцуулж, тэдний санал, зөвлөмжөөс сонссон юм.



Өвөлжилтийн хэрэгцээний нүүрс нийлүүлэлт

Энержи Ресурс компани нь “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн цахилгаан станцуудыг өвөлжилтийн хэрэгцээний нүүрсээр хангах ажлыг үйл ажиллагаа эхэлснээс хойш жил бүр зохион байгуулж ирсэн.

Энэ ажлын хүрээнд 2015 онд Өмнөговь аймгийн төвийн дулааны цахилгаан станц болон Ханбогд, Ханхонгор, Баян-Овоо сумдын цахилгаан станцын эрчим хүчний нүүрсний хэрэгцээнд нийт 25,200 тонн нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлж хамтран ажиллалаа. Ингэснээр орон нутгийн иргэд өвөлжилтийг хүндрэл багатай даван туулж, дулаан өвөлжих нөхцөл боломжоор хангагддаг.

Малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэв

Компанийн зүгээс орон нутгийн малчдад өвөл, хаврыг өнтэй даван туулахад нь туслах зорилгоор 2008 оноос өвс, тэжээлийн тусламж үзүүлж ирсэн. 2015 онд нийт 3,680 боодол өвс, 1,360 уут хивэг тэжээл худалдан авч, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Цогтцэций сумд болон Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн малчин өрхүүдэд тараах ажлыг орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагуудтай хамтран амжилттай зохион байгуулсан.



Сум дундын шинэ эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлээ

Орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, жишиг болгон хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор Цогтцэций сумын сум дундын шинэ эмнэлэгтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж, зохих тусламж, дэмжлэгүүдийг үзүүлж байна. Уг санамж бичгийн хүрээнд тайлант онд компаниас 54.2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлсэн.

Тэтгэлэгт сурагчид сургуулиа амжилттай төгслөө

Боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд чанартай боловсрол эзэмших боломж, нөхцлөөр хязгаарлагдмал сурагчдыг дэмжих зорилгоор сурлагын өндөр үзүүлэлттэй, тэргүүний есөн сурагчийг сонгон Кэмбрижийн олон улсын хөтөлбөрт хамруулж, сургалтын тэтгэлэг олгох ажлыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Уг тэтгэлэгт сурагчдаас 6 нь өнгөрсөн оны хавар сургуулиа амжилттай төгсч, бүрэн дунд боловсролын гэрчилгээгээ гардан авлаа. Эдгээр төгсөгчид улсын олимпиадад тогтмол тэргүүн байр эзэлж, сурлагын өндөр үзүүлэлттэй төгсөж буй бөгөөд бүгд АНУ, Европын дэлхийд нэр хүндтэй их, дээд сургуулиудын элсэлтийн болзлыг хангасан нь тэтгэлэгт хөтөлбөрийн үр дүнг илтгэн харуулж байна.



Монгол Ганжуур, Данжуурыг хөрвүүлэх үйлс

Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Цогт Цагийн Хүрдэн соёлын төвийн санаачлан хэрэгжүүлж буй Монгол Ганжуур, Данжуур их хөлгөн судрыг кирилл бичигт хөрвүүлж, олон нийтийн хүртээл болгох, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх буянт үйлсэд компанийн зүгээс 2013 оноос бодит хувь нэмрээ оруулан хамтран ажиллаж ирсэн.

Уламжлалт өв соёлыг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, орчин цагийн монгол хэлний үгийн санг баяжуулах, үндэсний бахархлыг бий болгох өндөр ач холбогдолтой энэхүү төслийг өнгөрсөн хугацаанд талархан дэмжсэний үрээр Ганжуур, Данжуурын их хөлгөн судрын хөрвүүлгийн эхний 140 боть бэлэн болж, орчуулагдан хэвлэгдсэн байна.



Тайлант онд уг төслийн хамтын ажиллагааны гэрээг дүгнэсэн бөгөөд төслийн санаачлагч Цогт Цагийн Хүрдэн соёлын төвийн зүгээс ном, судар бүтээх ариун үйлсэд тус компанийн оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж, талархал илэрхийлсэн юм

Аймгийн сайн малчдыг урамшуулаа

2015 оны 7-р сард Өмнөговь аймгийн 300 малчны зөвлөгөөн зохион байгуулагдсан. Энэ арга хэмжээнд Энержи Ресурс компанийн төлөөлөл оролцож, сум тус бүрээс шалгарсан тэргүүний 15 малчдыг өргөмжлөл, дурсгалын зүйлсээр шагнаж урамшуулсан. Мөн 84 жилийн ойн баяраараа Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон хүртсэн Өмнөговь аймгийн нийт удирдлага, малчид, төлөөлөгчдөд арга хэмжээний үеэр баяр хүргэн, хүндэтгэл үзүүлсэн.

Усны менежментийн сайн дурын кодекст нэгдэв

Олон улсын санхүүгийн корпорациас уул уурхайн компаниудтай хамтран “Өмнийн говийн ус ба уул уурхай” сэдэвт дугуй ширээний уулзалтыг тогтмол зохион байгуулдаг. Энержи Ресурс компани энэхүү дугуй ширээний уулзалтын гишүүн байгууллага бөгөөд үйл ажиллагаанд тогтмол идэвхитэй оролцож ирсэн.



Уулзалтын ач холбогдол нь уул уурхайн компаниудад усны менежмент болон түүнд хамааралтай оролцогч талуудын харилцааг зохицуулахад хамтарч ажиллах бололцоог олгодог. 2015 онд дугуй ширээний уулзалтын гишүүд болон холбогдох байгууллагууд хамтран “Усны менежментийн сайн дурын кодекс” боловсруулсан бөгөөд энэ баримт бичигт Энержи Ресурс компани мөн нэгдэн орсон. Ингэснээр кодекс нэгдэн орсон компани бүр усны менежментийг өндөр түвшинд хэрэгжүүлэх, усны хэмнэлттэй арга, технологи нэвтрүүлэх, ус ашиглалт, байгаль орчны чиглэлийн холбогдох бүхий л хууль, тогтоомжуудыг мөрдөн ажиллахаа сайн дураараа илэрхийлж байгаа онцлогтой юм.



Энержи Ресурс компани нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчны чиглэлийн холбогдох бүхий л хууль, стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН УДИРДЛАГА (БОХАБЭА)

Энержи Ресурс компани нь БОХАБЭА–н хүрээнд олон улсын ISO 14001:2004: Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон OHSAS 18001:2007: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо, стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА–н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг.

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлсэн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа Худаг төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Энэ хүрээнд Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

Өнгөрсөн онд салбарын нөхцөл, эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй хэдий ч байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг аль болох өндөр гүйцэтгэлтэй хэрэгжүүлэхийг зорьж дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Усны зохистой хэрэглээ

Энержи Ресурс компани нь олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг үндэсний уул уурхайн компани гэдэг утгаараа хариуцлагатай уул уурхай, тэр дундаа усны менежментийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Ялангуяа цэвэр усаар хомс говь нутгийн байгалийн онцлогийг дээд зэргээр харгалзан үзэж, усны зохистой хэрэглээг чухалчилдаг.

Ухаа Худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг бөгөөд дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилладаг. Ингэснээр уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, цэвэршүүлсэн ундны усаар хангаж байна. Мөн Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг байгуулж, үйлдвэрээс гарч байгаа нүүрсний лаг хаягдлаас усыг шавхан, дахин ашиглаж, үйлдвэрийн усны дахин ашиглалтыг 98 хувьд хүргэсэн. Түүнчлэн цахилгаан станцдаа тусгайлан агаарын хөргөлтийн технологи суурилуулсан учраас Монгол дахь бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4–5 дахин хэмнэдэг.

Үржил шимт хөрсний хадгалалт

Тайлант онд уурхайн шимт хөрсний овоолгын 1.4 га талбайд олон наст өвслөг болон нутгийн унаган ургамлуудыг тарьж ургуулсан. Ургамалжуулалтын ажилд шар царгас, хүцэнгэ, улаан, бор бударгана ашигласан ба нөмрөг ургамал болгож нэг наст судан өвс тарьсан. Энэхүү олон наст ургамлууд нь хөрсний ялзмагийн агууламжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.



Ногоон байгууламж, ургамалжуулалт

Орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Цэций” хороолол, цахилгаан станц, уурхайн засварын төвийн орчимд зүлэгжүүлэлт хийж, мод сөөг тарьж ургамалжуулсан. Тухайлбал “Цэций” хорооллын гаднах 4000 м.кв шороон талбайг зүлэгжүүлж, 700 мод тарин, 260м сөөгөн хашлага байгуулсан бол цахилгаан станцын гаднах талбайд 320 хайлаас, 20 шар хуайс, 150 жигд мод тус тус тарьж ургуулсан.



Мөн 1,010 м.кв талбайд шинээр зүлэгжүүлэлт хийж, цэцгийн мандал байгуулснаар цахилгаан станцын гадна талбайн 23% нь ногоон байгууламжтай боллоо. Түүнчлэн уурхайн засварын төвийн хойд талбайд засварын ажилчид өөрсдийн санаачилгаар 200 хайлаас, 50 жигд мод шинээр тарьж ургуулсан.

Шороон замын нөхөн сэргээлт

Шаардлагагүй шороон замуудыг хааж, нөхөн сэргээлт хийн, замын нэгдсэн сүлжээг ашигласнаар хөрсний элэгдэл, эвдрэл, тоосжилт зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, ан амьтдын амьдрах орчныг бүрдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.



2014 оноос эхлэн Цогтцэций сумаас Таван толгой нисэх онгоцны буудал хүртэлх хуучин шороон замуудыг хааж биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулснаар нийт 300 метрийн урттай зурваст мод тарьсан. Тайлант онд нэмж 100 метрийн урттай талбайд 380 ширхэг мод тарьсан төдийгүй цахилгаан станцын баруун талын хуучин шороон зам дагуу 500м² эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 640 жигд мод тарьсан.

Нөхөн сэргээлтийн туршилтын талбай

Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайд биологийн нөхөн сэргээлтэнд зориулан олон төрлийн мод, бут, сөөг, нутгийн болон олон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан тухайн бүс нутагт зохицсон ургамлыг сонгон шалгаруулж, улмаар нөхөн сэргээлт болон орчны тохижилтод ашиглах зорилготой ажиллаж байна.



2015 онд байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайд 3000 ширхэг сухайн мөчир, 1 кг жигдний үр, 10 кг хайлаасны үр, 0.5 кг загийн үрийг тус тус тарьж бойжуулсан. Мөн уг талбайд тарьж бойжуулсан 6955 ширхэг тарьц, суулгацыг орон нутгийн ногоон байгууламжийг дэмжих үүднээс Цогтцэций сумын засаг захиргаа болон нутгийн иргэдэд үнэ төлбөргүй хүлээлгэн өглөө.

Одоогоор дээрх талбайд Монгол орны байгалийн бүхий л бүсэд тархан ургадаг 22 төрлийн 26000 орчим мод сөөг болон үетэн, буурцагтан зэрэг олон наст бэлчээрийн ургамлуудыг тарьж ургуулан, туршилт судалгаа, үржүүлгийн ажил явуулж байна.

Хог хаягдлын менежмент

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ 3R+R системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Дахиврын цех”-ийг тогтмол ажиллуулж, блок, хашаа, сандал, хогийн сав зэрэг 11 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах зорилгоор хуванцар сав ангилан ялгаж хаях, түр хадгалах савны зураг төслийг бэлтгэж гурван эх үүсвэр дээр байрлуулсан бөгөөд засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тосыг зориулалтын саванд цуглуулж, хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлдэг. Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажиллаж байна.

Зэрлэг амьтдад тэжээл тавьж өгөв

Говийн бүс нутгаар өвөл цас бага орсны улмаас цасан бүрхэвчийн хэмжээ эрс багасч, зэрлэг амьтад ангах, усгүйдэх байдалд хүрсэн. Иймээс эдгээр амьтдыг өлдөж харангадах, хоол тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Цэций хайрхан” уулын зэрлэг туруутан амьтдад мөс, өвс тавьж өгөх ажлыг компаниас зохион байгуулж ажилласан. Ингэхдээ “Цэций хайрхан” уулын ар хэсгийн 10 газарт нийт 20 м3 мөс, 6 боодол өвс байрлуулсан. Компанийн зүгээс туруутан амьтдыг хамгаалах биотехникийн ажлыг “Цэций хайрхан” ууланд 2009 оноос эхлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.



Байгаль орчны хяналт, үнэлгээ

Гүний усны хяналт шинжилгээний ажлын хүрээнд малчдын 25 гар худаг, хяналтын 9 цооногт сард нэг удаа буюу нийт 104 удаагийн хээрийн хэмжилт хийж, хөндлөнгийн хяналтаар орон нутгийн иргэд малчдыг байлцуулав.

Мөн Ухаа Худаг уурхай, Цогтцэций сум орчмын тоосжилтыг хянах, бууруулах зорилгоор мониторингийн 13 цэг болон явуулын цэгүүдэд тоосны хэмжилтийг сар тутам хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд төрийн захиргааны холбогдох байгууллагуудаас хийгдсэн хяналт шалгалтаар Ухаа Худаг төслийн байгаль орчны үйл ажиллагааны гүйцэтгэлийг “хангалттай”, болзошгүй эрсдлийг “бага түвшинтэй” гэж тус тус үнэлсэн. Тухайлбал Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн хяналтаар тус төслийн цахилгаан станц ба Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг “бага эрсдэлтэй” гэж үнэлсэн бол 2015 онд хийж хэрэгжүүлсэн байгаль орчны ажлын гүйцэтгэлийг 89.5% буюу “хангалттай” гэж үнэлсэн.





ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЧИГ БАРИМЖАА

Ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг чухалчлан үзэж, эрүүл аюулгүй ажлын орчныг бий болгох нь бидний эрхэм зорилго юм. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн ажиллахыг эрмэлздэг. Хайгуул, ашиглалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл болон нөхөн сэргээлтийн бүхий л үе шатанд Энержи Ресурс компани нь ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний ач холбогдол өгч, “Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая” уриаг эрхэмлэн ажилладаг.

Тус компанийн Хөдөлмөрийн Аюулгүй Байдал (ХАБ)–ын нэгж нь Ухаа Худаг төслийн хүрээнд олон улсын OHSAS 18001:2007: Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Тайлант онд ноцтой осол гэмтэл гараагүй, мөн хугацаа алдсан гэмтлийн давтамж (LTIFR) 0.6 нэгжтэй гарсан нь олон улсын дунджаас ч доогуур үзүүлэлт бөгөөд компанийн зүгээс ХАБ–ын стандартууд, дүрэм журмуудыг өндөр түвшинд мөрдөн ажилласныг илтгэж байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА

Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, ажлын байрны үзлэг тогтмол хийх, зөрчлийг арилгуулах, ослын судалгаа хийх гэх мэт ажлууд компанийн хэмжээнд тогтмол явагддаг. 2015 онд ажлын байрны аюулгүйн үзлэгийг нийт 115 удаа зохион байгуулж, илэрсэн дутагдал зөрчлийг арилгахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Мөн ажиллагсад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, осол, эрсдлийн менежмент, анхны тусламжийн сургалт, зааварчилгаанууд тогтмол хийгдэж байна.

ХАБ –ын гол үзүүлэлтүүд	2013	2014	2015
Нийт ажилласан хүн/цаг	8,154,576	5,643,141	3,330,938
Эндэгдэл	1	2	0
Нийт гэмтлийн давтамж	3,56	5,32	2,7
Хугацаа алдсан гэмтлийн давтамж (LTIFRs)	1,23	1,24	0,6
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	–	87%	–
Алдсан хоногийн давтамж (ажиллаагүй хоног / ажилласан цаг)	0,000028	0,000158	0,0000282
ХАБ–ын сургалт, зааварчилгаа	12,881	12,681	5,149

ТОВЧ ДҮГНЭЛТ

Өнгөрсөн онд уул уурхайн салбарын хямрал үргэлжилсэн, хүндхэн жил байсан хэдий ч Энержи Ресурс компанийн зүгээс бүтэц, зохион байгуулалтын оновчтой хэлбэрт шилжих, бүтээмж дээшлүүлэх, зардал бууруулах зэргээр дотоод нөөц бололцоогоо дээд зэргээр дайчилж, үйл ажиллагаагааныхаа тогтвортой байдлыг хангахад анхаарч ажилласан.

Ингэснээр компанийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж, жилийн дүнгээр 83 тэрбум төгрөгийг татвар, шимтгэл хэлбэрээр төсөвт төвлөрүүлж, улс орны эдийн засагт өөрийн хувь нэмрийг орууллаа.

Энержи Ресурс компанийн зүгээс ажиллагсдын, тэр дундаа орон нутгийн болон шилжин суурьшсан ажиллагсдын ажлын байрыг аль болох хадгалах, тэдний нийгмийн баталгааг хангах тал дээр анхаарч, өөрсдөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Тайлант онд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн засаг захиргаа, малчид, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай хамтран орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, уламжлалт ажлуудыг хэвийн үргэлжлүүлж, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа.

Түүнчлэн байгаль орчны хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтран ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр санал, санаачилгатай ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдалд тасралтгүй анхаарснаар байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох бүхий л үзүүлэлтүүд олон улсын дунджаас ч амжилттай түвшинд гарч, холбогдох орон нутаг, мэргэжлийн байгууллагуудаас өндөр үнэлгээ авсан.

Энержи Ресурс компани нь өнөөдрийн тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг даван туулах, оролцогч талуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, бататгах замаар орон нутаг төдийгүй улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулах, улмаар олон улсын зах зээлд Монголын брэнд болсон нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн түвшний үйлдвэрлэгч компани байх зорилтоо хадгалан ажиллаж байна.

